



С.ОЮУНЧИМЭГ
ХСИС-ийн Эрх зүй,
нийгмийн ухааны
сургуулийн эрх зүйн
онолын тэнхимийн
ахлах багш, ахлах
дэслэгч

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ, ШИНЭЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын Үндсэн хуульд “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, хүн бүрийн амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байхыг тунхаглаж, төр нь хүний эрхийг баталгаатай хангах үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. Гэсэн хэдий ч нийгэм дэх гэр бүлүүдийн дунд хүчирхийлэл буурахгүй байна

Гэр бүлийн хүрээн дэх эрхийг хамгаалах, нийгэмд тогтсон сөрөг үзэлтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох талаар эрх зүйн асуудалтай холбогдох харилцааг хуулиар хэрхэн зохицуулж байсан талаар авч үзье.

1999 онд баталсан Гэр бүлийн тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл” гэдэг нэр томъёог анх

хэрэглэсэн бөгөөд гэрлэгсэд бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх¹, гэрлэгсдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан эсхүл, учирч болзошгүй бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйлгээр гэрлэлтийг цуцалж болохоор заасан. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ” гэсэн хэсэгт “гэрлэгсдийг тусдаа амьдрахыг даалгах” гэсэн заалт шинээр орсон нь хүчирхийлэгчийг тусгаарлах асуудлыг шийдвэрлэх зохицуулалт болж байсан юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчил, маргааныг ИХШХШ, Эрүүгийн, ЭБШ, Захиргааны хариуцлагын тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулийг удирдлага болгон шийдвэрлэж буй нь хүчирхийллийг шийтгэх, гэр бүл цуцлах зэрэг үр дүн муутай арга хэмжээ болж, хүчирхийлэл улам даамжирсаар л байна.

Ийм энэ харилцааг зохицуулахын тулд 2004 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг баталж, 2005.01.01-

нээс мөрдөж эхэлсэн. Энэ хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний оролцоог тодорхойлох, хохирогчийн эрхийг хамгаалах, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өмнөх хуулиудаар тодорхойлоогүй байгаа хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэгчид хүлээлгэх хариуцлагын шинэ хэлбэрийг буй болгох, зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн албадлагын арга хэмжээ хэрэглэх зэрэг шинэлэг зохицуулалтууд хуульчлагдсан байгаа хэдий ч:

❖ Уг хуулийн 3 дугаар зүйлд хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийн хувьд хэтэрхий ерөнхий дурьдсан

❖ 4 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаандаа баримтлах зарчмын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн II бүлэг, 16 дугаар зүйлд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдсэн зарим зарчмыг орхигдуулсан

❖ 5 дугаар зүйлд хуульд орсон нэр томъёоны тодорхойлолтыг оновчгүй тайлбарласан. Тухайлбал:

- “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг

зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;

- Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас гэр бүлийн гишүүн амь насаа алдсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, “Эрүүгийн хууль”-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхой/

- “Болзошгүй хүчирхийлэл” гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг;

- Тодорхойлж буй зүйл нэр томъёо нь тайлбартайгаа нийцэхгүй байна,

- /Болзошгүй хүчирхийлэл гэдгийг “хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал” хэмээн солин найруулах/ гэх мэт.

❖ 6 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэлийн хэлбэрүүдийг задлан тайлбарлаж тодорхой болгоогүй

❖ Хоёрдугаар бүлэгт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийг дурьдахдаа хэрэгжүүлэх чиг үүргийн зарим нь аль байгууллагад хамаарахыг тодорхой болгоогүй. Тухайлбал: Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийлэлийг таслан зогсоох үүднээс хохирогчийг хамгаалах

¹ “Гэр бүлийн тухай хууль”-ийн 10 дугаар

зүйл 3 дах хэсэг

байранд хүргэх, улмаар төрөл садангын хүмүүсийг түр хамгаалалтанд шилжүүлэх үүрэгтэй гэж заасан бөгөөд энэ чиг үүрэг нь Засаг даргын бүрэн эрхтэй агуулгын хувьд ижил байна. Хохирогчийг хамгаалах байранд хүргэх, төрөл садангын хүмүүсийг түр хамгаалалтанд үлдээх чиг үүрэг ямар тохиолдолд, аль байгууллагад хамаарах нь тодорхой бус байна²

❖ 19 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага хэтэрхий ерөнхий, нарийвчлан тусгагдаагүй зэрэг алдаа дутагдал байгаа нь судалгааны явцад тогтоогдсон.

2004 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль нь уг асуудалд холбогдох нийгмийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа төдийгүй хүчирхийлэлтэй холбогдолтой гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байсан. Иймээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг шинэчилэн найруулах болсон нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсон. Тухайлбал:

➤ 2004 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль дангаараа батлагдсан,

²ХСИС, “Эрх зүйн процесс: онол, практик” /эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/, УБ хот, 2015 он, 161 дэх тал

өөр хуулиудтай уялдаагүй учраас бодит амьдралд бууж хэрэгжих нь муу байсан. Тухайлбал: Хохирогч хуулийн хамгаалалт авъя гэхээр иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаад 60 хоногийн дотор шийдэгдэх гэсээр байтал амиа алдах,гэмтэж бэртэх, гарсан шийдвэр нь шийдвэр гүйцэтгэл дээр очоод биелэгддэггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулинд “тусдаа амьдрах” гэсэн шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх, хохирогчтой харилцаа тогтоохоор оролдсон бол яаж хянах заалт байгаагүй зэргийг дурдаа болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх 2004 оны хуулийг шинэчлэн найруулах ажил 2011 оноос эхэлсэн. 2011 онд хамгийн анх Засгийн газрын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2016.12.22-ны өдөр батлагдаж, 2017.02.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр хуульчлагдсан. Шинээр батлагдан гарсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг шинэчилсэн найруулгын давуу талыг дурдвал :

✓ Уг хуулийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийг тодорхой дурьдсан бөгөөд илүү өргөн хүрээнд авч үзэх болсон. Тухайлбал: Өмнө нь салсан эхнэр, нөхөр гэх мэт хүмүүс энэ

хуулийн хамгаалалтад ордоггүй байсан. Хамтран амьдарч байгаад больсон хосууд, дундаасаа хүүхэдтэй, гэр бүлийн баталгаагүй хүмүүсийн хооронд хүчирхийлэл үйлдэгдвэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль үйлчилдэггүй байсан.

✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажилагаанд баримтлах зарчмыг улам боловсронгуй болгосон. Тухайлбал:

- хохирогчийн нэр төрийг хүндэтгэх

- салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх

- нууцлалыг хамгаалах гэх мэт.

✓ 6 дугаар зүйлд Гэр бүлийн хүчирхийллийн төрлүүдийг нэлээд дэлгэрүүлж тайлбарласан.

✓ Хоёр дугаар бүлэгт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо”-г боловсронгуй болгож оруулсан бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, хохирогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд заавал оролцох субъектүүдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчилсан нь хууль хэрэгжих баталгаа болж байна. Үүнд: Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, албан тушаалтан хамрагдахаас гадна шинээр боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллагуудын эрх, үүргийг дурьдаж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой

✓ Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг мөн адил нарийн хуульчилж өгснөөс **иргэнд үүрэг болгосон зохицуулалт** орж ирсэн. Мөн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нууцыг чандлан сахиж, болзошгүй эрсдлээс хамгаалах зэрэг зохицуулалт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэхэд чухал байр суурийг эзэлнэ. Харин мэдсээр байж мэдээлэл өгөөгүй, иргэнийхээ үүргийг биелүүлээгүй тохиолдолд Захиргааны

хариуцлагын тухай хуулинд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэлийг хуульд оруулсан.

✓ Гэр бүлийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалах зохицуулалт шинээр орж ирсэн /2004 оны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулинд энэхүү заалт байгаагүй/ нь ихээхэн ач холбогдолтой. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл, түүний нөлөөнд бий болж байгаа гэр бүл салалт нийгэмд ихэссээр байна. Үүний гол хохирогч нь хүүхэд болж үлддэг. Тэдний эрх ашгийг хамгаалах механизм нийгэмд зайлшгүй шаардлагатай байна.

✓ Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ. Энэ нь тухайн нөхцөл байдал дахь

хүчирхийллийн хэлбэр, амьдрах орчин дахь эрсдэл, хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох ач холбогдолтой

✓ Хохирогчид үзүүлэх үйлчилгээний шинэ механизм бий болсон. Хүчирхийлэгч тэжээгч гэдэг үндэслэлээр хариуцлагаас мултрахгүй. Хохирогчийн амьдралын баталгааг хангах зорилгоор хуульд заасан үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэх үүрэгтэй. Тухайлбал: /Уг хуулийн 5 дугаар бүлэг/

- эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- нийгмийн халамжийн үйлчилгээ
- холбон зуучлах үйлчилгээ гэх мэт

✓ Гэр бүлийн зөрчлийн асуудлаа хүчирхийллийн бус аргаар шийдэхэд суралцуулах, өөрийнхөө бурууг ойлгож засах үүний дараагаар гэр бүлдээ очих боломжийг олгох зорилгоор зан үйлд нь нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар хуулинд тусгагджээ. Өөрөөр хэлбэл: Энэхүү хууль нь хүчирхийлэл үйлдлээ гээд нэг бол гэрлэлтийг нь шууд цуцлах эсвэл хүнд ял эдлүүлэхээс аль болох татгалзах, эргээд хүчирхийлэлтэй харилцаанаас салах боломжийг гэр бүлд олгох зорилготой хууль юм.

Сайн дурын болон албадан сургалт гэсэн хоёр хэлбэртэй байх юм. Сайн дурын сургалт ял шийтгэлийн журмаар биш албадан нь ял шийтгэлийн журмаар. Өнөөдөр

сайн дурын сургалтад сууя гэсэн хүмүүс зөндөө ирдэг. Би асуудлаа шийдэхээсээ өмнө түрүүлээд эхнэр рүүгээ гар далайчихаад болдоггүй ээ. Үүнийгээ яаж засах вэ гээд өөрийгөө мэдрээд байгаа хүмүүс бий.

✓ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо өөрчлөгдсөн. Тухайлбал: Өмнө нь гэр бүлийн хүчирхийллийг иргэд хоорондын маргаантай адилхан шийдвэрлэдэг байсан. Эдийн засгийн, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон бол шүүхээр асуудлаа шийдүүлдэг байсан. Одоо бол **гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил** гэж үзэж гэмт хэрэгт тооцох болсон. Гэмт хэрэгт тооцогдохооргүй үйлдлүүдийг “захиргааны зөрчил” гэж үзнэ. Ялгамжтай ял, шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг дагалдаад, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд орсон өөрчлөлтөөр энэ зохицуулалтуудыг хийсэн. Захиргааны хариуцлагын тухай хуулинд зөрчил ба гэмт хэргийг заагласан. Зөрчилд зодох, хүсэл зоригийнх нь эсрэг албадах, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох, эд хөрөнгө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд халдах гэх мэт 7 үйлдэл Захиргааны

зөрчил болсон. Хэрэв энэ үйлдлүүдээ давтан хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэдгийг хуульчилсан. Захиргааны зөрчилд 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулна, гэмт хэрэг үйлдсэн бол эхний удаа, хөнгөрүүлэх нөхцөлтэй бол 1-6 сар хүртэл баривчлах, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй, жирэмсэн эмэгтэйг зодох, хүүхдийг байнга зодсон тохиолдолд хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялтай.

Хэрэг шалгах явцад хохирогчийг заналхийлдэг, өргөдөл гомдлоо буцаагаад авахыг дарамталдаг. Үүнийг зогсоох зорилгоор Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулсан. Хохирогчид тодорхой зайд ойртох, ажлын байран дээр нь очих дарамтлахыг хориглосон. Хэрэв тогтоосон хязгаарлалтыг зөрчвөл цагдан хорих гэх мэтээр дараагийн арга хэмжээг авна гэсэн шинэлэг зохицуулалтуудыг тусгаж өгсөн нилээд шинэлэг зохицуулалт болсон байна.